



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/302

Номгон


Хүн амыг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын  
эсрэг вакцинаар дархлаажуулахад хөрөнгө  
гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг чанартай, хариуцлагатай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулах үйл ажиллагааг аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулахад шаардагдах 7.000.000 /долоон сая/ төгрөгийг Засаг даргын нөөцөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Энхжаргал)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621010773